

Ус ба ой мод



Усгүйгээр дэлхий дээр амьдрал оршин тогтнох нөхцөлгүй. Тийм болохоор ой модыг усны худаг гэж хэлэхэд хилсдэхгүй. Модны бас нэгэн чухал үүрэг нь усыг урсгахгүй тогтоон барих юм.

Хөрсний ялзмагт үе давхаргад ургаж байгаа өвс, хөвд, модны үндэс нь борооны усыг их хэмжээгээр шингээдэг. Зөвхөн хөвд өвс гэхэд л өөрийнхөө хэмжээнээс 10 дахин их ус шингээх чадвартай. Модны үндэс бусад ургамлын бүрхүүлийн хамтаар хөрсний гулгалт, хүчтэй аадар бороонд хөрс нурж урсахаас хамгаалдаг бөгөөд - хамгийн чухал үүрэг нь усыг тогтоон барьж, нөөцлөх юм.

Хур тунадас гүний усанд шингэснээр (ойн хөрсний нэвтрүүлэгч чанар нь биологийн найдвартай шүүлтүүр болдог) хөрсөн доорх ус, булаг шандны усны нөөцийг нэмэгдүүлдэг. Мэдээж хэрэг хур тунадасны тодорхой хувь нь ууршина. Зөвхөн хөрсний гадаргуугаар тогтохгүй модны их бие ялангуяа навчнаас ус ууршдаг.

Тэгвэл навчит мод илүү их ус ууруулдаг байх нь ээ?

Хэрвээ модны навчийг эхнээс нь дуустал нь нэгбүрчлэн тоолох юм бол асар том хэмжээний навчин талбай бий болно. Нарны хурц гэрэл нь навчны дулаан ялгаруулалтыг богино хугацаанд ихэсдэг тул навч сүв хөндийгөөрөө дамжуулан ус ууршуулж илгэсээ хамгаалдаг. Тийм болохоор навчаа хамгаалахын тулд модны ууршуулж байгаа усны хэрэгцээ нь фотосинтез явуулахаас харьцангуй их байдаг.

Ууршсан ус нь ойн бичил уур амьсгалыг зөөлрүүлж энэ нь хүмүүст эерэгээр нөлөөлдөг. Халуун өдөр ойд сэрүүхэн, чийглэг агаартай байдаг нь үүнтэй холбоотой. Ойн хөрсний өнгөн хэсэг нь усыг их хэмжээгээр өөртөө шингээдэг тур хур тунадасгүй үед жижиг гол горхи энэ уснаас эх авдаг. Өнгөрсөн түүхийн хугацаанд манай орны нутаг дэвсгэрт их хэмжээний ойн талбайг бүлгээр нь огтолсноор ус цуглуулах нөхцөлгүй болж олон гол горхи усгүй болсныг бид мэдэх билээ. Хавар цас хайлах үед ой мод усыг цуглуулж жигд хэмжээгээр хуваарилдаг.



Ус ямар их ямар ач холбогдолтой болохыг мэдэх үү?




Дэлхийн хамгийн том нуур, гол мөрнүүдийг нэрлэвээс

- Дэлхийн хамгийн урт мөрөн Амазонка – 6 762 км
- Дэлхийн хамгийн гүнзгий нуур – Байгаль нуур 1 642 м
- Дэлхийн хамгийн том нуур Каспийн тэнгис 371 000 км²
- Дэлхийн хамгийн том цутгалан Салто Ангел (Венесуел) 1 049 м
- Монголын хамгийн урт гол Орхон гол – 1 124 км
- Монголын хамгийн том нуур Увс нуур – 3 350 км²

Сонирхолтой тоо баримтаас дурдахад...

- Дэлхийн гадаргуугийн 70% ус эзэлдэг.
- Төрөөд гурав хонож байгаа нярайн биений 87%, 8 сартай хүүхдийн 85%, 65 насанд хүний биений 70% ус эзэлдэг.
- Дэлхийн ундны усны нөөцийн 77% цас мөс, 22% гүний ус, зөвхөн 1% гадаргуугийн гол мөрөн, нуурын ус эзэлж байна.
- Ойн экосистемийн усны ууршилт 10%, нуга хөндий 25%, тариан талбай 45%, нүцгэн талбай 100 % байдаг.
- Ойн экосистемийн вегетацийн өнгөн давхаргын усны ууршилт 30%, ургамлын аймаг 25%, талбайн экосистем 15% байдаг.
- Бусад экосистемтэй харьцуулахад ой нь хур тунадасны усыг хамгийн үр дүнтэйгээр хөрсөн доорх ус болгон хувиргах чадвартай.
- Гацууртай харьцуулахад жодоо мод жилд 1 350 м³ ус илүү ялгаруулах чадвартай.
- Навчит ойтой харьцуулахад гацууран ой хур тунадасны усыг 2 дахин, нуга хөндийгөөс 4 дахин бага гадагшлуулдаг.
- 100 кг элс 25 л, 100 кг хар шороон хөрс 50 л, 100 кг ялзмаг хөрс 150 л, 100 кг хөгшин ойн мод 300 л усыг тус тус цуглуулдаг.
- Ой нь хөрсийг эвдрэлд орохоос найдвартай хамгаалж чаддаг!



Сургалтын жим нь „МОНГОЛ ОРНЫ ОЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ОЙ МОДНЫ ГЕНИЙН САНГИЙН ХӨГЖИЛ” ТӨСлийн хүрээнд хөгжлийн хамтын ажиллагааны нэг хэсэг болон бий болсон.

